

## ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

### Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл


Д/д	Төслийн нэр	“Гурвантэс-XXXV” талбайд нүүрсний давхаргын метан хийн хайгуулын ажил гүйцэтгэх
1.1	1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгжийн нэр	“Тэлмэн ресурс” ХХК
	2. Аж ахуй нэгжийн Улсын бүртгэлийн дугаар	9019097333
	3. Аж ахуй нэгжийн үйл ажиллагааны чиглэл	09100 Уламжлалт бус газрын тос / Нүүрсний давхаргын метан хий / хайх.
	4. Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	Баянзүрх дүүрэг, Намянжүгийн гудамж, Нийслэл төв, 9 дүгээр давхар Утас: 976-7015-5517
	5. Захиралын нэр, утас, цахим шуудангийн хаяг	В.Ганзориг Гар утас 88107575, <a href="mailto:gvanchig@telmenresource.com">gvanchig@telmenresource.com</a>
	6. Мэргэжилтний нэр утас, цахим шуудангийн хаяг	Б.Сарангоо Гар 99001459, Ажил 80001459, <a href="mailto:b.sarangoo@telmenresource.com">b.sarangoo@telmenresource.com</a>
1.2	1. Төслийн нэр	Гурвантэс XXXV төсөл
	2. Төсөл хэрэгжих байршил	Өмнөговь аймгийн Гурвантэс, Ноён сумдын нутагт
	3. Төслийн ангилал	Хайгуул
	4. Төсөл эхэлсэн огноо	2021.09.08 Хайгуулын тусгай зөвшөөрөл авсан.
	5. Төсөл хэрэгжих хугацаа	2021-2031 он
	6. ТЭЗҮ баталсан огноо	2021.07.27 Гурвантэс-XXXV талбайд нүүрсний давхаргын метан хийн хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар ашигт малтмал газрын тосны газар болон Тэлмэн Ресурс ХХК-ийн хооронд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээ / Хавсралтаар оруулсан /
	7. Тухайн жилийн ажиллах хүчний тоо	60-80 / 60 хүн ростерийн ажилтнууд, 20 хүн зочид төлөөлөгчид /
	8. Урьд оны хийсэн ажлын хэмжээ	2022 онд Хайгуулын 5 цооног өрөмдсөн
	9. Тухайн жилийн хийх ажлын төлөвлөгөө	2023 онд чөмгөн дээж бүхий баганат өрөмдлөгийн 8 цооног, туршилт олборлолтын 3 цооног өрөмдөхөөр төлөвлөж туршилт олборлолтын 3 цооног өрөмдөж туршилтын үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байна.

## НЭГ.ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

“Тэлмэн Ресурс” ХХК (цаашид “компани”) нь Газрын Тосны хуулийн дагуу Өмнөговь аймгийн Гурвантэс, Ноён сумдын нутаг 8398,61 км<sup>2</sup> талбайг хамарсан ГУРВАНТЭС-XXXV төслийн талбайд нүүрсний давхаргын метан хийн БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭ -г Ашигт Малтмал, Газрын Тосны Газартай байгуулж, 2021 оны 9 сарын 8 өдөр хайгуулын ажлын тусгай зөвшөөрөл аван хайгуулын ажлаа эхлүүлээд байна.

“Тэлмэн Ресурс” ХХК нь ГУРВАНТЭС-XXXV төслийн талбайд өмнөх эрлийн ажлын хүрээнд НДМХ –ийн өрөмдөгдсөн цооногуудын мэдээллийн боловсруулалт, хоёр хэмжээст чичирхийлэлийн судалгаа, нүүрсний давхаргын 3 хэмжээст загварчлалын ажлуудыг хийж гүйцэтгэн улмаар хайгуулын талбайн хэмжээнд хэтийн төлөвийн баялагийг тооцоолсон. Төслийн талбайд дунд палеозойгоос орчин үеийн хүртэлх насны хурдас чулуулаг тодорхой структуруудад их бага хэмжээгээр тархсан байдаг ба ерөнхийдөө зүүнээс баруун тийш сунасан тогтоцтой байдаг. Энэ тогтоцын дагуу дээд перм, триасын конгломератын зузаан давхаргатай харьцангуй нарийн элсжин, алевролиитоос тогтсон атираажсан формацууд нь голлон нүүрс агуулсан байдаг. Бид төслийн хоёр хэмжээст чичирхийллийн судалгаагаа хийн нүүрс агуулсан формацууд нь тохролыг дагасан моноклиналь бүтэцтэй байгааг тогтоон улмаар талбайд өмнөх нүүрсний хайгуулын цооног, метан хийн 6 цооногийн үр дүнг боловсруулж үнэлгээ өгч, талбайн хэмжээнд тархсан нүүрс дэх хийн агуулга дунджаар 8.75 м<sup>3</sup>/т байна гэж үзсэн бөгөөд судалгааны ажлын түвшинээр “проспект” ба “лийд” талбайнуудыг ялган тус тусд нь хэтийн төлөвт баялагуудыг тооцоолсон. “Проспект” түвшинд эрсдэлгүй оновчтой зэргээр 57.2 тэрбум м<sup>3</sup>, эрсдэлтэй оновчтой зэргээр 51.5 тэрбум м<sup>3</sup> гэж хэтийн төлөвт баялаг байна гэж тооцоолсон.

2023 онд Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нарийн сухайтын бүлэг орд тэр дундаа МАК ХХК-ийн талбайд Туршилт олборлолтын 3 цооног өрөмдсөн. Туршилт олборлолтын цооногийн үйл ажиллагаатай холбоотой бүтээн байгуулалтуудыг хийж гүйцэтгээд байна. Нүүрсний Давхаргын Метан Хийн олборлолтын нөөцийг тогтоох зорилготойгоор Шилдэг чадварлаг боловсон хүчнүүдийг удирдлагын багтаа томилон ажиллаж байна.




**Зураг 1. Туршилт олборлолтын талбайн ерөнхий байршил**

### **1.1 ТУРШИЛТ ОЛБОРЛОЛТЫН ЦООНОГ ӨРӨМДӨХӨД АШИГЛАСАН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ТЕХНОЛОГИ**

Туршилт олборлолтын өрөмдлөгийн ажлын хөтөлбөрийн дагуу цооног өрөмдлөгийн ажил 2022.03.21-ний өдөр эхэлж 2023.05.30-ны өдөр хүртэл нийт 72 өдрийн хугацаатай өрөмдлөгийн ажлыг хийж дуусгасан. Хөтөлбөрийн хүрээнд Тэлмэн Ресурс ХХК нь Нарийн сухайтын нүүрсний ордын талбайд анхны метан хийн туршилт-

олборлолтын үйл ажиллагааг 2023 оны 7 сарын 13-ны өдрөөс эхлүүлэн өнөөг хүртэл туршилт-олборлолтын үйл ажиллагааг үргэлжлүүлж байна.

Туршилт олборлолтын цооног өрөмдлөгийн ажилд “Мэйжор Дриллинг Монголиа” компани LF\_001, LF\_002, LF\_003 цооногуудын ажлыг хийж гүйцэтгэсэн бол “Галакси Жео Монголиа” ХХК-тай хамтран цооногийн геофизикийн хэмжилтийн ажил хийж гүйцэтгүүлсэн.



**Зураг 2. Туслан гүйцэтгэгч Мэйжор Дриллинг Монголиа ХХК-ний Schramm T130XD  
маркийн өрмийн машин**

“Мэйжор Дриллинг Монголиа” ХХК нь Schramm T130XD маркийн баганат өрөмдлөгийн машинаар өрөмдлөгийн ажлыг хийсэн ба тус техникийн үндсэн үзүүлэлтүүд нь:

- 760 морины хүчтэй (567 кВт) минутад 1800 эргэлттэй мотор
- 415 л багтаамжтай 2 түлшний сав
- 1.52 м сэнс бүхий хоёр голтой хөргөлтийн системтэй, орчны температур 54°C ажиллах боломжтой
- Гидравлик удирдлагатай

- Бүрэн сунгасан үед 21.25 м өндөртэй
- HRC удирдлагаар хувьсах эргэлтийн хурд
- Ажлын дээд даралт 3000 psi (208 bar)
- 578 кН өргөгчийн хүчин чадалтай
- 38.1 м/мин татах хурдтай
- 82.3 м/мин буулгах хурдтай

### **Туршилт олборлолтын цооног өрөмдлөгийн талбайг бэлтгэх ажил**

Туршилт-олборлолтын цооног өрөмдлөгийн талбайг бэлтгэх дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- Талбайн зураг төслийн дагуу 76\*60 харьцаатай 3 өрөмдлөгийн талбайг тэгшлэх, цэвэрлэх, хөрс дагтаршуулах, хамгаалалтын хөмсөг татах, орц гарц гаргах газар шорооны ажил хийж гүйцэтгэв.
- 3 талбайн хэмжээнд маркшейдер цэг татах ажил гүйцэтгэсэн
- Орон нутаг болон МАК-аас газар хөндөх зөвшөөрөл авсан
- Өрөмдөх 3 талбай тус бүрт 12x18 м-ийн хэмжээтэй өрөмдлөгийн хаягдал усан сан (зумп) байгуулсан.
- Өрөмдлөгийн 3 талбайг холбосон тээврийн хэрэгсэл зорчих зам байгуулах ажил хийсэн.
- Туршилт олборлолтын үйл ажиллагааг хянах ажилчдын оффис, агуулах, ариун цэврийн барилга байгууламжийг барих ажлуудыг хийсэн.
- Туршилт-олборлолтын үйл ажиллагааг цахилгаанаар хангах цахилгааны шугам сүлжээний ажлыг хийж гүйцэтгэв.

### **Туршилт олборлолтын цооног өрөмдлөгийн ажил**

Туршилт олборлолтын 3 цооног өрөмдлөгийн ажлыг ажлыг төлөвлөхдөө 2022 онд өрөмдсөн SL\_002 хайгуулын цооногийн өрөмдлөгийн үр дүнд үндэслэн дунд-дээд Триасаас доод Юрийн насны нүүрс агуулсан Ноёнсум формацийг 515 м хүртэл өрөмдөхөөр төлөвлөн өрөмдлөгийн хөтөлбөр боловсруулж, цооногийн хийц зохиосон. Цооногийн өрөмдлөгийн ажлыг “Мэйжор Дриллинг Монголиа” ХХК 21 хүний бүрэлдэхүүнтэй баг Schramm T130XD өрмийн машинаар 2023 оны 4 сарын 12-ны өдөр эхлүүлэн 5 сарын 30-ны өдөр хүртэл өрөмдсөн. Цооног өрөмдсөн гүн хүртэл каротажийн хэмжилтийн ажлыг “Галакси Жео Монголиа” ХХК 2 хүний бүрэлдэхүүнтэй хийж гүйцэтгэсэн.

## Хүснэгт 2. Өрөмдсөн туршилт-олборлолтын цооногуудын мэдээлэл

№	Цооногийн дугаар	Өрмийн компани	Өрөмдсөн гүн, м	Өргөрөг	Уртраг	Өндөржилт
1	LF-01	M.D.M LLC	375.0	43°0'11.55"	101°12'23.51"	1531
2	LF-02	M.D.M LLC	407.13	43°0'07.24"	101°12'35.73"	1531
3	LF-03	M.D.M LLC	515.0	43°0'2.96"	101°12'31.01"	1521

## Хүснэгт 3. Каротажийн хэмжилт, боловсруулалт хийсэн тэмдэглэл

Цооногийн дугаар	Каротажийн хэмжилт, боловсруулалт				
	Dens-Cal-Gamma	Resistivity	Vertical Deviation	LAS	Хэмжилт хийсэн компани
LF-01	Ү	Ү	Ү	Ү	Галакси Жео Монголиа ХХК
LF-02	Ү	Ү	Ү	Ү	Галакси Жео Монголиа ХХК
LF-03	Ү	Ү	Ү	Ү	Галакси Жео Монголиа ХХК

Монкаротаж ХХК каротажийн хэмжилт боловсруулалтыг хайгуулын цооног тус бүрд үндсэн таван аргачлал (чулуулгийн эсэргүүцэл, калибер, байгалийн гамма, цооногийн нягт)-аар хийсэн.

## Хүснэгт 4. Туршилт олборлолтын цооног (LF-01, LF-02, LF-03) өрөмдлөгийн ерөнхий хураангуй

Гол ажилбарууд:	<ul style="list-style-type: none"> <li>• Нүүрсний бүлэг дээд давхаргыг босоо цооногоор нэвтэлж өрөмдсөн.</li> <li>• 7" -ийн ховилтой олборлолтын янданг нүүрсний давхаргуудад суулгав.</li> <li>• Бүх үйл ажиллагааг эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчны осол аваргүйгээр явуулсан.</li> </ul>
Техникийн гол ажилбарууд:	<ul style="list-style-type: none"> <li>• Нүүрсний дээд бүлэг давхарга хүртэл 12 ¼" -оор өрөмдсөн. 9-5/8" -ийн голчтой бэхэлгээний яндах суулгаж, ханыг цементлэх ажил хийгдсэн.</li> <li>• 8-3/4" -ийн голчтойгоор нүүрсний дээд бүлэг давхаргын улаас доош ~50м хүртэл өрөмдсөн.</li> <li>• Өрөмдсөн гүн хүртэл каротажийн хэмжилт хийгдсэн.</li> <li>• 7" инчийн олборлолтын янданг нүүрсний бүлэг дээд давхаргад суулгав</li> <li>• 3 1/2" олборлолтын яндан хоолойг суулгав</li> </ul>



Тойм ажилбарууд:	<ol style="list-style-type: none"> <li>1. Өрөмдлөгийн шингэн зуурч 12-1/4” эргэлтэт цооногийн үзүүрийн багажинд аваачин өрөмдлөгийн нэвтрэлтийг гүнзгийрүүлэх үйл ажиллагаа явагдсан</li> <li>2. Цооног өрөмдөж эхлэхдээ 12-1/4” инчийн 4% -ын KCl/Polymer зуурмаг зуурж дээд нүүрсний давхаргийн таац хүртэл өрөмдлөг хийгдсэн.</li> <li>3. 9-5/8” инчийн хэмжээтэй бэхэлгээний яндан суулгаж хурдан хатдаг нягт ихтэй цементийг насосоор шахсан.</li> <li>4. Бэхэлгээний янданд даралтын тест хийсэн.</li> <li>5. Оргилолтоос хамгаалах төхөөрөмж (ВОР) суулгаж даралтыг шалгасан.</li> <li>6. 8-3/4” инчийн хэмжээтэй цооногийн үзүүрийн багажийг угсарч ВНА зохиогдсон.</li> <li>7. 8-1/2” инчийн хэмжээтэй цооног нийт гүн хүртэл өрөмдөнө.</li> <li>8. 7” нүхтэй бэхэлгээний янданг цооногт суулгасан.</li> <li>9. Цооногийн амсарыг иж бүрэн угсарч ВОР – ыг буулгав .</li> <li>10. Түбийн иж бүрдэл болон РСР насосыг цооногт суулгаж дууссан.</li> <li>11. Цооногийг .битүүмжилж өрмийн нүүлгэн шилжүүлэлт хийгдсэн</li> </ol>
------------------	---



**Зураг 3. Нарийн сухайтын нүүрсний ордын талбайн нүүрсний давхаргын метан хийн туршилт-олборлолтын 3 цооног (LF-01; LF-02; LF-03)-ийн байршлын бүдүүвч зураг**



**Зураг 4. Туршилт-олборлолтын цооног (LF-02) өрөмдлөг хийх явц**



**Зураг 5. Туршилт-олборлолтын цооног (LF-01)-оос үртсэн дээжлэл хийх явц**



### **1.1.1 ТУРШИЛТ ОЛБОРЛОЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД АШИГЛАЖ БАЙГАА ТОНОГ ТӨХӨӨРӨМЖҮҮД**

Тэлмэн Ресурс ХХК нь туршилт-олборлолтын цооног өрөмдлөг болон цооног өрөмдөж дууссаны дараа нүүрсний усны шавхалт, хийн туршилтын олборлолтын үед дараах багаж төхөөрөмжүүдийг ашиглан ажилласан байна. Үүнд:

#### ***Өрөмдлөгийн үед хэрэглэгдсэн тоног төхөөрөмжүүд:***

- ✓ Цооногийн амсрын тоноглол
- ✓ Өрмийн хошуу
- ✓ Угаалгын шингэн
- ✓ Бэхэлгээний яндан
- ✓ Бэхэлгээний яндангийн иж бүрдлүүд
- ✓ Олборлолтын яндан хоолой
- ✓ Олборлолтын яндан хоолойн иж бүрдлүүд
- ✓ Торк анкер

#### ***Олборлолтын цооногийн шахуургын тоног төхөөрөмжүүд:***

- ✓ Сүмбэн бүлүүр
- ✓ Сүмбэн бүлүүрийн иж бүрдлүүд
- ✓ Олборлолтын насос
- ✓ Цооногийн толгойн байгууламж

#### ***Гадаргууд суурилагдах тоног төхөөрөмжүүд:***

- ✓ Хий-шингэний урсгалын тоолуур
- ✓ HDPE хоолой
- ✓ Удирдлагын хянах самбар
- ✓ Цахилгаан эрчим хүчний иж бүрдлүүд
- ✓ Бамбарлан асаах төхөөрөмж
- ✓ Усны шахуурга



Зураг 6. Туршилт-олборлолтын цооног (LF-02) цементлэх явц



Зураг 7. ВОР суурьлуулах үйл явц



**Зураг 8. Цооногийн толгойн амсрын байгууламж, өрөмдлөгийн ажил дууссаны дараах байдал**

**Туршилт олборлолтын цооногт хийсэн геологийн зүсэлт болон хийгдсэн ажлууд**

**LF-01** цооногийн зүсэлт нь литологийн хувьд 60 м гүн хүртэл дунд-дээд Триасаас доод Юрийн насны Ноёнсум формацийн жижгээс дунд ширхэгт цул нягт текстуртай саарал өнгийн элсэн чулуу болон алевролитын салаавчилсан үелэл, 180 м хүртэл дунд-дээд Триасаас доод Юрийн насны Ноёнсум формацийн нягт хатуу конгломерат болон дундаас том ширхэгт элсэн чулуу, гравелитаас тогтоно. 180-280 метрийн гүнд дунд-дээд Триасаас доод Юрийн насны Ноёнсум формацын харилцан адилгүй зузаантай нүүрсний давхаргууд болон тэдгээрийн дундах аргиллит, алевролит, элсэн чулууны үеүдээс тогтоно. 280 метрээс дунд ширхэгтэй саарал өнгийн элсэн чулуу болон алевролитоос тогтох бөгөөд эдгээрийн дунд нүүрсний маш нимгэн үеүдээс тогтоно.

Цооногт 34 см диаметртэй бэхэлгээний яндан 6 м хүртэл суулгасан. 6 метрээс 155 м хүртэл 24.45 см диаметр бүхий өрмийн хошуу ашиглан өрөмдсөн ба нүүрсний давхарга эхлэхээс өмнө өрөмдлөгийн ажлыг зогсоон цооногт бэхэлгээний яндан суулган цооногийн ханыг цементлэх ажил хийсэн. Цемент хатсаны дараа чулуулгийн даралт даах чадварыг уршиж үзсэн. Туршилт амжилттай болсны дараа 17.78 см диаметр бүхий өрмийн хошуу ашиглан 375 м гүн хүртэл өрөмдсөн.

Өрөмдлөгийн ажлаар нийтдээ 51 м зузаан бүхий нүүрсний 22 үе давхаргыг нэвтэлсэн. 155 м гүн хүртэл цооногоос 3 м тутамд нэг дээж авсан түүнээс доош 2 м тутамд нэг дээж авсан. Цооногийн гүн болон помпны эргэлтийн хурдад үндэслэн тухайн дээж ямар хугацааны дараа гадаргууд гарч ирэхийг тухай бүрд нь тооцоолон уг хугацаанд дээжийг авсан.

**LF-02** цооногийн зүсэлт нь литологийн хувьд 120 м гүн хүртэл дунд-дээд Триасаас доод Юрийн насны Ноёнсум формацын жижгээс дунд ширхэгт саарал өнгийн элсэн чулуу болон алевролитын салаавчилсан үелэл байна. 120 м гүнээс 220 м хүртэл дунддээд Триасаас доод Юрийн насны Ноёнсум формацын нягт хатуу конгломератаас тогтооно. 220 метрээс доош гүнд харилцан адилгүй зузаантай нүүрсний давхаргууд болон тэдгээрийн дундах аргиллит, алевролит, элсэн чулууны үеүдээс тогтоно.

LF\_02 цооногт 6.1 м гүн хүртэл 34 см диаметртэй бэхэлгээний яндан суулгасан. 6 метрээс 227 м хүртэл 24.45 см диаметр бүхий өрмийн хошуу ашиглан өрөмдсөн ба нүүрсний давхарга эхлэхээс өмнө өрөмдлөгийн ажлыг зогсоон цооногт бэхэлгээний яндан суулган цооногийн ханыг цементлэх ажил хийсэн. Цемент хатсаны дараа чулуулгийн даралт даах чадварыг туршиж үзсэн. Туршилт амжилттай болсны дараа 17.78 см диаметр бүхий өрмийн хошуу ашиглан 407.13 м гүн хүртэл өрөмдсөн.

Өрөмдлөгийн ажлаар нийтдээ 46.2 м зузаан бүхий нүүрсний 17 үе давхаргыг нэвтэлсэн. 227 м гүн хүртэл цооногоос 3 м тутамд нэг дээж авсан түүнээс доош 2 м тутамд нэг дээж авсан. Цооногийн гүн болон помпны эргэлтийн хурдад үндэслэн тухайн дээж ямар хугацааны дараа гадаргууд гарч ирэхийг тухай бүрд нь тооцоолон уг хугацаанд дээжийг авсан.

**LF\_03** цооногийн зүсэлт нь литологийн хувьд 70 м гүн хүртэл дунд-дээд Триасаас доод Юрийн насны Ноёнсум формацын хүрэн, улаан хүрэн өнгөтэй элсэн чулуу болон алевролитын салаавчилсан үелэл, 70-190 хүртэл гүнд дунд-дээд Триасаас доод Юрийн насны Ноёнсум формацын саарал өнгийн элсэн чулуу алевролитын үелэл байна. 190 м гүнээс 300 м хүртэл конгломератаас тогтооно. 5 харилцан адилгүй зузаантай нүүрсний давхаргууд болон тэдгээрийн дундах аргиллит, алевролит, элсэн чулууны үеүдээс тогтоно.

6.1 м гүн хүртэл 34 см диаметртэй бэхэлгээний яндан суулгасан. 6 метрээс 320 м хүртэл 24.45 см диаметр бүхий өрмийн хошуу ашиглан өрөмдсөн ба нүүрсний давхарга эхлэхээс өмнө өрөмдлөгийн ажлыг зогсоон цооногт бэхэлгээний яндан суулган цооногийн ханыг цементлэх ажил хийсэн. Үүний дараа 17.78 см диаметр бүхий өрмийн хошуу ашиглан 515 м гүн хүртэл өрөмдсөн.



Өрөмдлөгийн ажлаар нийтдээ 44 м зузаан бүхий харилцан адилгүй зузаантай нүүрсний 20 үе давхаргыг нэвтэлсэн. 320 м гүн хүртэл цооногоос 3 м тутамд нэг дээж авсан түүнээс доош 2 м тутамд нэг дээж авсан. Цооногийн гүн болон помпны эргэлтийн хурдад үндэслэн тухайн дээж ямар хугацааны дараа гадаргууд гарч ирэхийг тухай бүрд нь тооцоолон уг хугацаанд дээжийг авсан.

### **Туршилт олборлолтын цооног гүйцээлтийн ажил**

Тэлмэн Ресурс ХХК нь туршилт-олборлолтын цооног өрөмдлөгийн ажлыг амжилтай дуусгасаны дараа цооног гүйцээлтийн ажлыг 2023 оны 5 сарын 30-наас 7 сарын 13-ны хооронд “Мэйжор Дриллинг Монголиа” ХХК хийж гүйцэтгэсэн. Цооног гүйцээлтийн ажил дараах үе шатуудаар цооногийн гүнд хийгдсэн. Үүнд:

- Гүний мэдрэгч багаж (downhole gauge) суурьлуулалт
- Төвөөс зугатах хүчний насос (PCP) суурьлуулалтын ажил
- Цооногийн хөтлөгч мотор (drivehead) суурьлуулалтын ажил



**Зураг 9. Туршилт олборлолтын цооногийн хөтлөгч мотор (drivehead) суурьлуулсаны дараах байдал**

### **Туршилт олборлолтын талбайн гадаргуугийн бүтээн байгуулалтын ажил**

Нүүрсний давхаргын метан хийн туршилт-олборлолтын талбайг цахилгаан эрчим хүчээр хангах, хий, усны шавхалтын үйл ажиллагааг хянах, цооногоос шавхагдсан хий, нүүрсний усыг зайлуулах зорилгоор Тэлмэн Ресурс ХХК нь дараах үе шатны ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Туршилт-олборлолтын цооногийн хажууд хий, шингэний урсгал хэмжигч багц тоног төхөөрөмжийн суурьлуулалт
- Туршилт-олборлолтын талбайг цахилгаан эрчим хүчээр хангах
- Цооногоос шавхагдсан хийг бамбарлан шатаах төхөөрөмж угсралт
- Цооногоос шавхагдсан нүүрсний усыг түр цуглуулах далангийн бүтээн байгуулалт
- Цооногоос шавхагдсан нүүрсний усыг зайлуулах шугам хоолойн бүтээн байгуулалт
- Туршилт-олборлолтын үйл ажиллагааг хянах ажилчдын оффис барилга байгуулалт

### **Туршилт олборлолтын цооногийн хажууд хий, шингэний урсгал хэмжигч багц тоног төхөөрөмж болон галын бамбарлан шатаах төхөөрөмжийн суурьлуулалт**

Туршилт-олборлолтын цооногийн хажууд хий, шингэний урсгал хэмжигч багц тоног төхөөрөмж (Meter Run Skid)-ийг суурилуулахад шаардагдах үндсэн ажлуудыг доор харуулав.

1. Хий, шингэний урсгал хэмжигч багц тоног төхөөрөмжийг угсран суурьлуулах талбайг тэгшлэн нягтруулсан.
2. Цооногийн толгойн амсрын байгууламжийн дамрыг цооногийн амсар дээрх цагираг ба хоолойн хавхлагуудтай холбосон.
3. Хий, шингэний урсгал хэмжигч багц тоног төхөөрөмийг зөв байрлалд байрлуулж уян хоолойг холбох боломжтой болгосон. Хийн урсгалын зам нь P&ID-ийн дагуу зөв, урсгал хэмжигч дээр тэгш байгаа эсэхийг шалгасан.
4. Уян хоолойг цооногийн амсарт, урсгал хэмжигчтэй холбогдсон хоолойг жийргэвчтэй боож бэхлэсэн.
5. Урсгал хэмжигчээс тээвэрлэлтийн явцад салгагдсан дагалдах тоног хэрэгслүүдийг угсрах суурьлуулах (Жишээлбэл: Бамбардах галын яндан) ажлыг гүйцэтгэсэн.
6. Уян хоолойг урсгал хэмжигч төхөөрөмжийн хийн гаралтаас бамбардах галын шугам хоолойн фланц руу шургуулж холбож боосон.
7. Цооногийн амсараас ойролцоогоор 30м зайд, зам, цахилгаан дамжуулах шугам, нүүрсний овоолгын зэргэлдээ биш байдлаар галын бамбарын байршлыг хамгийн тохиромжтой байрлалд тодорхойлсон.

8. Шаардлагатай 2 7/8" хоолойн 2 эсвэл 3 уртыг хэмжиж, шаардлагатай галын бамбарын байршил болон байршлын цэгийн тодорхойлсон.
9. 2 7/8" хоолойны эхний холбоосыг галын бамбарын яндан хоолойруу шургуулж холбосон ба мөн урсгал хэмжигч төхөөрөмжрүү буцах хүртэл холболтыг хийсэн. 50NB ANSI150 х 2 7/8" EUE гадна резватай холбогч гол дамарыг яндан хоолойн төгсгөл хэсэгт шургуулж холбосон.
10. Шугам хоолойг ойролцоогоор газрын түвшнөөс 150 мм-ээс дээш түвшинд модон блок дээр өндөрлөсөн. Хоолойн холболт бүрийг олон талт ган тулгуур гадасаар эсвэл ижил төстэй найдвартай холболтоор газарт бэхэлсэн.
11. Галын бамбарын шугам хоолойг урсгал хэмжигчийн хийн гаралтын уян хоолой руу хөндлөн фланцтай боолтоор холбосон.
12. Стандартын дагуу урсгал хэмжигч ба галын бамбарын хоолойн газардуулгыг гүйцэтгэсэн.



**Зураг 10. Туршилт-олборлолтын цооногийн хажууд хий, шингэний урсгал хэмжигч багц тоног төхөөрөмжийг суурьлуулсан байдал**



**Зураг 11. Туршилт олборлолтын цооногийн хажууд бамбарлан шатаах төхөөрөмж суурилуулсан байдал**

### **Туршилт-олборлолтын талбайг цахилгаан эрчим хүчээр хангах**

“Тэлмэн Ресурс” ХХК нь туршилт олборлолтын талбайг өндөр хүчдэлийн шугамаас цахилгаанаар хангах ажлын хүрээнд 380 квт гүйдэл дамжуулах трансформаторыг “МАК” ХХК-ийн мэргэжилтнүүдээр угсруулж гүйцэтгүүлсэн. Талбайн цахилгаан хангамж, гадна гэрэлтүүлэг, камержуулалтын ажлыг “Би И Инженеринг” ХХК хийж гүйцэтгэсэн.

Талбайн цахилгаан хангамжийн ажлын хүрээнд оролтын ерөнхий самбарыг суурилуулах, оролтын ерөнхий самбараас 4 ш самбарын хуваарилалт хийн тэжээлийг өгсөн.

Гадна гэрэлтүүлгийн ажлыг хийхдээ нийт 4 м өндөртэй 5 ш гэрлийн шонг суулгаж ажиллагаанд оруулсан. Гадна гэрэлтүүлэг тус бүрийг хуваарилах самбарын ойролцоо суулгаж, гэрлийн тэжээлийг тухайн хуваарилах самбараас авсан.

Хяналтын камержуулалтыг хийхдээ туршилт-олборлолтын талбайд нийт 5 ш гадна зориулалтын камерыг суулгаж ажиллагаанд оруулсан. Тус камерудад зориулсан 6 м-ийн өндөртэй шон суулган камерийг байршуулсан. Дохио дахин дамжуулагч access point ашиглан дүрсийг дамжуулан оффисын хэсэгт дэлгэц дээр камерыг гаргасан.







**Зураг 13. Туршилт-олборлолтын цооногийн талбайд байгуулагдсан шавхалтын ус түр цуглуулах далан болон туршилт-олборлолтын цооногуудын байрлалыг харуулсан дрон зураг**

### **Цооногоос шавхагдсан нүүрсний усыг зайлуулах шугам хоолойн бүтээн байгуулалт**


Цооногоос шавхагдсан нүүрсний усыг зайлуулах шугам хоолойн зураг төслийг “Силвер Эделвэйз” ХХК хийж гүйцэтгэсэн бөгөөд зураг төсөл боловсруулахад Монгол улсад одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Барилгын норм ба дүрэм болон стандартын холбогдох заалтуудыг баримталсан. Инженер геологийн “Лэнд Тест” ХХК-ийн 2020 онд хийсэн “Өмнөговь аймгийн Гурвантэс сум. SGS-Нарийнсухайт уурхайн орчмид төлөвлөгдөж буй 1.4 км ус дамжуулах шагмаын инженер-геологийн дүгнэлт (Архив №20/367) болон инженер-геодезийн “ДиЭмТиЭй Инженеринг” ХХК-ийн 2023 оны 3 сарын 26-28-ны өдөр төслийн талбайн 2 долгионы GPS ашиглан боловсруулсан М1:1000 хураангуйлалтай дэвсгэр зургийг тулгуур материал ашиглав.

Шавхалтын ус зайлуулах шугамын материалыг сонгохдоо угсралт, суурилуулалтын онцгой шаардлага тавигдахүй, дотоодын барилгын үйдвэрлэлд хэрэглэдэг материалтай тохирсон, олон улсын ISO9001 болон GB/T19001 стандартын шаардлага хангасан хүчитгэсэн хуванцар хоолой (HDPE) хэрэглэсэн. Шугамын хоолойг автозамтай хөндлөн гарах хэсэгт DN300 ган хоолойд сүвлэж хийсэн. Шугам хоолойн хадан хөрстэй хэсэгт 10 см зузаан элсэн бэлтгэл үе /шавар, шигшсэн шороо/ хийсэн.

Шугам хоолой ил эсвэл бага гүнд суурилагдсан хэсэгт 5 см зузаан полиуретан хөөсөнцөрөөр дулаалга хийлээ. Шугам хоолой материалыг ISO9001 болон ISO14001 стандартын шаардлага хангуулсан.



**Зураг 14. Туршилт олборлолтын цооногоос шавхагдсан нүүрсний усыг зайлуулах шугам хоолой барилтын явцын зураг**



Зураг 15. Туршилт олборлолтын цооногуудын байрлал тэдгээрийн хажууд байгуулагдсан шавхалтын ус түр цуглуулах далангаас зайлуулагдах усыг карьерлуу цутгах зорилгоор байгуулагдсан шугам хоолойн зураг




## **Туршилт олборлолтын үйл ажиллагааг хянах ажилчдын оффис барилга байгуулалт**

“Тэлмэн Ресурс” ХХК нь туршилт-олборлолтын үйл ажиллагааг хянах, цооногоос олборлогдсон хий, шингэний урсгалыг хэмжигч багц тоног төхөөрөмжөөс ирж буй тоон мэдээллийг хүлээн авч компьютерт боловсруулах ажлыг газар дээр нь хийх зорилгоор туршилт-олборлолтын талбайд ажилчдын байрлах оффис болон ариун цэврийн барилга байгууламжуудыг барьж байгуулсан.



**Зураг 16. Туршилт-олборлолтын цооногийн талбайд байгуулагдсан шавхалтын ус түр цуглуулах далан болон туршилт-олборлолтын цооногуудын байрлалыг харуулсан дрон зураг**



**Зураг 17. Туршилт олборлолтын цооног шавхагдаж олборлогдсон хий болон**

**усны хэмжээ, урсгалын хурд, гидростатик даралтын утгыг хянах Scada системийн программ хангамжийг суулгасан хяналтын компьютер**

**ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

**2.1 БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ**

**2.1.1 Газрын гадаргуу:** Манай орны физик газарзүйн мужлалаар газрын гадаргын хувьд Алтайн уулархаг их мужийн Говь-Алтайн мужид багтах бөгөөд салхи шороон шуурга их, салхины дундаж хурд 4-6 м/сек. хойноос зүүн урагш өргөргийн дагуу сунаж тогтсон Хан Хүрэн ба Зурамтайн нурууны уулархаг бүсэд хамрагдана. Үнэмлэхүй өндөр нь далайн төвшинөөс дээш 1100-1600 м юм.

**2.1.2 Цаг агаар:** Халуун зунтай, хуурайвтар уур амьсгалын мужид, зөөлөвтөр өвөлтэй дэд мужид хамардаг. Агаарын жилийн дундаж температур  $+4^{\circ}\text{C}$   $+6^{\circ}\text{C}$ , 1-р сарын дундаж температур  $-15^{\circ}\text{C}$   $-20^{\circ}\text{C}$ , 7-р сарын дундаж  $+25^{\circ}\text{C}$   $+30^{\circ}\text{C}$ , хамгийн их халуун нь 7-р сард  $+38^{\circ}\text{C}$   $+40^{\circ}\text{C}$ , хамгийн хүйтэн нь 12-р сард  $-36^{\circ}\text{C}$   $-38^{\circ}\text{C}$  хүрдэг. Агаарын чийгшил багатай жилд дунджаар 45-50% байгаа нь хуурайвтар болохыг харуулна. Ус чийг багатай, хуурай уур амьсгалтай учир манан бараг ажиглагдахгүй, 70-80 % нь 7-8 р сард ордог. Өвөлдөө цас маш бага, цасан бүрхүүл бараг тогтдоггүй бөгөөд 1-2 см ихдээ 10 см байна. Жилийн 30 орчим хоног хур тунадастай.

**2.1.3 Хөрс ургамал:** Говийн хөрсний их мужийн цөлөрхөг хээрийн бүсэд багтдаг. Хур тунадас ховор, эрс гандуу уур амьсгалтай, өвс ургамал тарчиг сийрэг энэ талбай нь говийн бор хөрстэй. Хөрс үүсэх явц гандуу нөхцөлд явагдах учир салхины үйл ажиллагаа хөрсний агаарын солилцоог идэвхжүүлж, ууршилтыг ихэсгэн хуурайшихад нөлөөлж өвс ургамлыг хийсгэн тараах тул зөвхөн үндэсний зарим нь ялзмаг болдгоос органик үлдэгдлийн хэмжээ маш бага 1% -иас бараг үл хэтэрнэ. Иймээс сайр чулуу ихтэй хуурай хагсуу карбонатлаг байдгаас нийтлэг мараалаг шинж үл ажиглагдана. Харин хонхор, хотгор, тойром, булаг шанд бүхий газруудаар хужир мараа энд тэнд тогтсон байна. Говийн цаг уур, хөрсний онцлогоос шалтгаалан ургамлын нягтшил багатай, сийрэг тачир хөрсийг нийтэд нь бүрхэж чаддаггүй энд тэнд хэсэг хэсгээрээ ургадаг боловч шимт чанартай байдгаараа онцлог юм. Энд агь, шарилж, таана, мангир, хөмөл, монгол өвс, хазаар, баглуур зэрэг олон наст ургамал, чихэр өвс, цулхир, гоёо зэрэг эмийн ургамал,

хайлаас, тоорой, сухай, заг, жигд, зэгэс, зээргэнэ, буларгана, хармаг, харгана гэх мэтийн модлог, бутлаг говь цөлийн ургамал ургадаг. Хавар 4-р сараас ургамал ургаж эхлэх ба 9-р сараас гандаж эхэлдэг. Модлог бутлаг ургамлыг нутгийн хүмүүс багаар түлшинд, хөмөл, гоёо, чихэр өвс, хармагны жимс зэргийг хүнсэнд болон эмчилгээнд ашигладаг байна. Говийн эдгээр ургамлууд нь элсний нүүдэл, цөлжилтийн үйл явцыг тогтоон барьж байхад чухал ач холбогдолтой.

**2.1.4 Амьтны аймаг:** Энд говь цөлийн амьтад болох хулан, аргаль, янгир, хар сүүлт зэрэг туурайтан, махчин амьтдаас чоно, шилүүс, хярс, үнэг, өмхий хүрэн, мануул, жигүүртнээс бүргэд, тас, шонхор, харцага, элээ, ногтруу, тагтаа, болжмор, хулан жороо, хэвлээр явагчдаас олон зүйл гүрвэл, могой, мэрэгчдээс туулай, алаг даага, чичүүл, бозлог, шавьж идэштнээс зараа, шавьжаас хэдэн төрлийн аалз, арваалж, ямаан ууц, байх ба эдгээр амьтдаас нэн ховордсон, устаж алга болохын даваан дээр байгаа төрөл, зүйлүүдийг агнах, устгахыг хориглож дархан цаазтай болгожээ.

**2.1.5 Ус зүй:** Хайгуулын талбай нь төв Азийн гадагшаа урсгалгүй ай савын бүсэд багтдаг. Талбайн хэмжээнд гадаргуугийн усан сүлжээ муу хөгжсөн ба байнгын урсгал ус байхгүй. Талбайн хэмжээнд жижиг булгууд байх боловч эдгээр нь тухайн жил улирлын цаг уур, хур тунадасны хэмжээнээс хамаарч усны горим хувьсамтгай зарим үед гандаж ширгэдэг. Хуурай сайр, тойрмууд нь хур тунадас ихтэй үед усаар дүүрээд богино хугацаанд хөрс болон агаарт ууршин ширгэдэг. Хүн малын усны хэрэгцээнд голлон худгийн ус хэрэглэх ба багаар булаг шандын ус ашигладаг. Залуу хагарлууд дагасан дөрөвдөгчийн хурдсанд хуурай сайр нуурын зах хавийг бараадуулан гар болон өрөмдмөл гүний худгууд гаргасан байдаг бөгөөд эдгээрийн усны түвшин 1-7 м хүртэл гүнтэй, эрдэсжилт ихтэй байна.

## **2.2 ГУРВАН ТЭС, НОЁН СУМЫН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСАГ**

### **2.2.1 Гурвантэс сумын нийгэм, эдийн засаг**

Гурвантэс сум нь 1945 онд Сэврэй, Ноён сумуудын багуудыг нийлүүлж Улаан толгой гэдэг газарт 281 өрх, 946 хүн ам, 63.2 мянган малтай байгуулагдсан бөгөөд Өмнөговь аймгийн нийт газар нутгийн 16.9 хувийг эзэлдэг. Газарзүйн байршлын хувьд Хойд талаараа Баянхонгор аймгийн Шинэжинст, Баянговь, Баянлиг сумуудтай хиллэдэг. Урд талаараа БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эзний хошуутай хиллэж, “Шивээ хүрэн” боомтоор хоёр улсын ложистик дамжин өнгөрдөг.

**Хүн ам:** Аймгийн нийт хүн амын 7.4 хувь нь тус суманд оршин суудаг байна. Хүн амын нягтрал нь 1.0 кв.км талбайд 0.18 хүн ногдож, маш бага нягтралтайд тооцогддог. Хүн амын тоо болон газар нутгийн хэмжээгээр аймагтаа тэргүүлдэг. Гурвантэс сум нь Гоёот, Баясах, Тост, Урт багийн нийт 1558 гаруй өрхтэй. Сумын хэмжээнд 2020 оны эцсээр 5043 хүн тоологдсон, өмнөх оноос 83 хүнээр буюу 1.6 хувиар өсчээ. Нийт хүн амын 20.5% нь мал аж ахуй эрхэлж амьдарч байна.

Гурвантэс сумын хүн амын орон зайн тархан суурьшсан нутаг дэвсгэрийг авч үзвэл: Урт багийн нутаг дэвсгэрт нийт хүн амын 40 гаруй хувь суурьшсан байгаа нь дэд бүтэц, төрийн захиргааны анхан шатны нэгж, эрүүл мэндийн төв, боловсролын байгууллага зэрэг төр болон хувийн хэвшлийн үйл ажиллагаа явуулдаг сумын төв байрладаг байна. Баясах болон Тост багуудад нийт хүн амын 20 гаруй хувь тус бүрт суурьшсан байгаа нь мал, аж ахуй болон үйлдвэрийн байршлыг хамааран суурьшсан. Гоёот багт сумын хүн амын 17.4% нь суурьшсан байдаг боловч судалгааны талбайн нутаг дэвсгэрт хэсэгхэн нутаг дэвсгэр орж байгаа. Хүн амын 39.9 хувь хүүхэд багачууд, 33.8 хувь нь залуучууд эзэлж байна. Үлдсэн 26.3 хувийг 40-ээс дээш насны хүмүүс эзэлж байна. 2020 оны байдлаар 1.9 хувиар буюу 31 өрх шинээр бүртгэгдсэн. Тус сумын өрхийн амьжиргааны түвшин жилээс жилд сайжирч байгаа бөгөөд зэргэлдээ сумуудтай харьцуулахад эдийн засгийн өсөлт ихтэй сум юм. Гурвантэс сумын 2020 жилийн эцэс 1648 өрхийн 887 өрх нь мал аж ахуй эрхэлж амьдарч байна. Нийт өрхийн 53.6.% мал аж ахуй, 47.4% суурин газарт уул уурхайн болон төр, хувийн хэвшилд ажиллаж байна.

**Эрүүл мэнд:** Гурвантэс сумын эмнэлэг нь 2021 оны байдлаар 16 эмч сувилагч, 8 туслах ажилтан нийт 26 ажилтантай ажиллаж байна. “Айвенхоу Майнз Инк” ХХК-ийн хөрөнгө оруулалтаар эмч, ажилчдын 2 орон сууцыг барьж, ашиглалтад оруулсан байна. Сумын хүн эмнэлгийн салбар нь өөрийн сумын нийт хүн ам болон хилийн цэргийн 0166 дугаар анги, уул уурхайн компаниуд иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байна. Ковид-19 цар тахалын дэгдэлттэй холбоотойгоор сумын эмнэлэг ПСР шинжилгээний лабораторитой болсон.

**Мал аж ахуй:** Бэлчээрийн мал аж ахуйн судалгаанаас авч үзэхэд тэмээ, ямааны аж ахуй өсгөх нэн зохистой бүсэд хамрагдаж байгаа боловч сүүлийн жилүүдийн байгаль экологи, уур амьсгалын өөрчлөлттэй уялдан бэлчээрийн ургамлын гарцад өөрчлөлт орохын зэрэгцээ зарим нэг унаган ургамлуудын төрөл зүйл ч алга болжээ. Эдгээр



хүчин зүйлүүдийг тогтоох шалгуур үзүүлэлтэд малын тоо толгой зүй ёсоор багтдаг. Малтай өрхийн тоо болон малын тоо буурсан нь сүүлийн жилүүдэд өвөл зудтай байгаагаас шалтгаалж байгаа бөгөөд мөн уул уурхайн үйл ажиллагаа эрчимжиснээр газрын хөрсийг талхлан, ургамлын гарцанд нөлөөлж байгаатай холбоотой. 2020 оны эцэст 237.7 мянган толгой мал тоолуулжээ. Нийт малын 88.2% нь ямаа, 5.3% нь хонь, 4.2% нь тэмээ, 1.9% нь үхэр, 0.2% нь адуу. Тус сумын малчин өрх ямааг ноолуур болон эдийн засгийн үр ашгаар тооцоолж өсгөдөг боловч бэлчээрийг талхлах нөлөөтэй.

### **2.2.2 Ноён сумын нийгэм, эдийн засаг**

Ноён сум нь 1923 онд Өмнөговь аймгийн анхны сумуудын нэг болон байгуулагдсан. Газарзүйн байрлалын хувьд баруун талаараа Гурвантэс сум, зүүн талаараа Баяндалай сум, Хойд талаараа Сэврэй сум, урд талаараа БНХАУ-ын ӨМӨЗО-ны хошуудтай хиллэдэг. Засаг захиргааны анхан шатны нэгж нь Сайран, Ганзагад гэсэн хоёр багаас бүрдэнэ. Сумын эдийн засгийн голлох салбар нь мал аж ахуй юм.

**Хүн ам:** Өмнөговь аймгийн нийт хүн амын 2.0 хувь нь тус суманд оршин суудаг байна. Хүн амын нягтрал нь 1.0 кв.км талбайд 0.13 хүн ногдож, маш бага нягтралтай байна. Хүн амын тоогоор Өмнөговь аймгийн 15 сумаас хамгийн бага, газар нутгийнхаа хэмжээгээр аймагтаа хоёрт ордог. Ноён сум нь Сайран, Ганзагад багийн нийт 447 өрхтэй. Сумын хэмжээнд 2020 оны эцсээр 1408 хүн тоологдсон нь өмнөх оноос 14 хүнээр буюу 1 хувиар өсчээ. Тус суманд халхчууд голлон амьдардаг. Нийт хүн амын 30.7% нь мал аж ахуй эрхэлж амьдарч байна. Ноён сумын хүн амын орон зайн тархан суурьшсан нутаг дэвсгэрийг авч үзвэл: Сайран багийн нутаг дэвсгэрт нийт хүн амын 53.7 хувь суурьшсан байгаа нь дэд бүтэц, төрийн захиргааны анхан шатны нэгж, эрүүл мэндийн төв, боловсролын байгууллага зэрэг төр болон хувийн хэвшлийн үйл ажиллагаа явуулдаг сумын төв байрладаг байна. Ганзагад багт нийт хүн амын 46.2 хувь суурьшсан байгаа нь мал аж ахуй болон бэлчээрийн байршлаас хамааралтай. Ноён сумын өрхийн тоо 2003-с 2020 он хүртэл тогтмол 0.5 хувийн өсөлттэй жигд бага өссөн байна. Тус сумын өрхийн амжиргааны түвшин жигд байгаа бөгөөд зэргэлдээ сумуудтай харьцуулахад эдийн засгийн өсөлт багатай сум юм. Нийт өрхийн 60% нь мал аж ахуй, 40% нь суурин газарт төр, хувийн хэвшилд ажилладаг.


**Эрүүл мэнд:** Ноён сумын эмнэлэг нь 2020 оны байдлаар 6 их эмч, 2 бага эмч, 6 сувилагч, нийт 28 ажилтантай ажиллаж байна. Тус 2 сумын эмнэлэгүүд нь үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд болон сумын удирдлагуудын оролцоотойгоор эмнэлэг нь орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангагдсан. 2019 онд улсын төсвийн хөрөнгөөр 15 ортой шинэ сум дундын эмнэлэг ашиглалтанд орсон.

**Мал аж ахуй:** Бэлчээрийн мал аж ахуйн судалгаанаас авч үзэхэд тэмээ, ямааны аж ахуй өсгөх нэн зохистой бүсэд хамрагдаж байгаа боловч сүүлийн жилүүдийн байгаль экологи, уур амьсгалын өөрчлөлттэй уялдан бэлчээрийн ургамлын гарцад өөрчлөлт орохын зэрэгцээ зарим нэг унаган ургамлуудын төрөл зүйл ч алга болжээ. Сумын малын тоо 2000-2010 оны хооронд 67000 тоо толгойгоор хорогдож буурсан. Малтай өрхийн тоо болон малын тоо буурсан нь сүүлийн жилүүдэд өвөл зудтай байгаагаас шалтгаалж байгаа бөгөөд мөн уул уурхайн үйл ажиллагаа эрчимжиснээр газрын хөрсийг талхлан, ургамлын гарцанд нөлөөлж байгаатай холбоотой. 2020 оны байдлаар Ноён сум нь 138.6 мянган толгой мал тоолуулжээ. Нийт малын 82.1% нь ямаа, 9.8% нь хонь, 5.6% нь тэмээ, 0.2% нь үхэр, 1.9% нь адуу байна.

## **ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ**

Хайгуулын ажиллагааны явцад газрын доорх усны нөөцийн бохирдол, хомсдол, ургамлан нөмрөгийн өөрчлөлт, хөрсний элэгдэл, зэрлэг ан амьтдын байршилт, тархалтын өөрчлөлт, эрчим хүчний хэрэглээ нэмэгдэх, тэрчлэн агаар, ус, хөрсний бохирдол үүсэх зэрэг сөрөг нөлөөллүүд хамаарна.

Эдгээр сөрөг нөлөөллийг бууруулах болон арилгах арга хэмжээний үр дүн нь байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа нь шинжлэх ухааны үндэслэл бүхий зохион байгуулалт, техникийн арга хэмжээнүүдийг цогц бүрдэл байх бөгөөд эдгээр арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр тухайн хайгуулын талбай болон кемпийн эргэн тойрон дахь бүс нутагт үйл ажлаллагааны явцад экологийн зөвшөөрөгдөх норм, норматив хангагдаж байх ёстой.



### **Байгаль орчинд нөлөөлөх гол нөлөөллүүд**

Төслийн үйл ажиллагаанаас орчны агаар, ус, хөрс, ургамал, амьтан, газрын хэвлийд үзүүлэх нөлөөллийн байдалд нарийвчилсан дүн шинжилгээ хийлгэсэн. Хайгуулын ажлын нэг төрөл нь сейсмийн хайгуул ажиллагаа бөгөөд энэ нь газрын хэвлийд үүсгэх зориудын чичирхийлэл, түүний хариу үзүүлэх долгионы тархалт юм.

**Хүснэгт 5. 2D сейсмийн хайгуулын явцад байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл**

Хүрээлэн буй орчин ба нийгмийн хүчин зүйлс	Голлох нөлөө	Нөлөөлөлд өртөх боломжтой объектууд
<b>Физик газар зүй</b>	Зарим газарт онгон зэрлэгээрээ байгаа газар орчны харагдах байдлыг өөрчилнө	Газар орчин
<b>Гадаргын усны нөөц</b>	Гол горхи орчны урсац, гольдролыг өөрчлөх	Хөрс гадаргын орчны гол горхи булаг шанд
<b>Гүний усны нөөц</b>	Гүний усыг ашиглана (бага зэрэг нөлөөлнө), шингэн хорт бодисын ялгарлаар хөрс, гүний усыг бохирдуулах, судалгааны суурин орчмоос хэрэглээний бохир усаар газрын гүний ус руу нэвчих бохирдуулах	Хөрс, гадаргын болон гүний ус
<b>Хүрээлэгч амьтан ургамал</b>	Биологийн төрөл зүйлийн амьдралд нөлөөлөх, ургамал талхлагдах, шувууд болон жижиг мэрэгчдийн амьдрах орчинд нөлөөлөх	Биологийн төрөл зүйлүүд
<b>Нийгэм эдийн засаг</b>	Ажлын байрны боломж, төвлөрсөн суурин үүсэх Дэд бүтэц хөгжих, сайжрах, малын бэлчээрт сөргөөр нөлөөлөх	Хүн нийгмийн хүчин зүйлүүд

## Хүснэгт 6. Уг төслөөс хүрээлэн буй орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөлөл

№	ХБО ба нийгмийн параметрууд	Нөлөөлөх эх үүсвэр	Таамагласан нөлөөлөл
1	Физик газарзүй ба геологи	Вибросейс ба түүнтэй холбоотой дагалдах төхөөрөмжүүд,	Хайгуулын шугамууд нь урт хугацаанд нөлөөлөх ул мөрүүдийг үлдээнэ. (Зам дээр автомашины мөр болон газрын гадаргад ул мөр үлдээх) Чичирхийлэгч нь бага хэмжээний газрын гулсалт болон чулуулгийн бат бөх тогтвортой байдлыг алдагдуулна.
2	Хөрс	Вибросейс ба түүнтэй холбоотой дагалдах төхөөрөмжүүд, нефть болон техникийн шингэн бодисын асгаралт	Хайгуулын шугамын дагуух дагтаршсан хөрсний доройтол, мөн хөрсний үе давхарга алдагдах, мөн энэ дагуу ус хөрсний элэгдэл эвдрэл нэмэгдэх боломжтой, сул хөрсний алдагдал болон нүх сүвшилт үүсэх, хөрс бохирдох;
3	Уур амьсгал	Байхгүй	Байхгүй
4	Агаарын чанар	Автомашин ба тоног төхөөрөмж, хог хаягдлын цэг	Техникийн яндангаас ялгарах бохирдол, замын хөдөлгөөнөөс үүсэх тоосжилт, таагүй үнэр, эрүүл мэндийн эрсдэл
5	Гадаргын ба гүний усны нөөц	Машин ба хүнд техник, Өрөмдлөг	Орон нутгийн иргэдтэй усны эх үүсвэрийг хуваалцахад асуудал үүсэх боломжтой, уст үеийн дагтаршил, булаг шандын ундарга багасах, цооног өрөмдсөнөөр хөрсний усны төвшин доошлох
6	Усны чанар	Шингэн бодисын ялгаралт, машин хүнд техник ба түлш хадгалах савнаас ялгарах бодис	Судалгааны суурингийн усны эх үүсвэрийн бохирдол, Хөрсний уст үеийн бохирдол
7	Биологийн хүчин зүйлс	Вибросейс ба түүнтэй холбоотой дагалдах төхөөрөмжүүд, бульдозер, хүнд машин техникүүд,	Хайгуулын шугамын дагуу ургамал талхлагдах, ан амьтны амьдрах орчинд нөлөөлөх, Шинэ хортой ургамлын төрөл зүйл нэмэгдэх
8	Усан орчны төрөл зүйлүүд	Вибросейс ба түүнтэй холбоотой дагалдах төхөөрөмжүүд, бульдозер, хүнд машин техникүүд,	Усан орчныг бохирдуулах, амьдрах орчинд таагүйгээр нөлөөлөх
9	Газрын нөөц ба соёлын өв	Вибросейс ба түүнтэй холбоотой дагалдах төхөөрөмжүүд, бульдозер, хүнд машин техникүүд, динамит	Хайгуулын шугам бэлчээр орчинд нөлөөлөх, соёлын өвд нөлөөлөх нөлөөлөл нь нутгийн иргэдийн сэтгэлд нийцэхгүй байх
10	Археологи ба түүх соёлын өв	Вибросейс ба түүнтэй холбоотой дагалдах төхөөрөмжүүд, бульдозер, хүнд машин техникүүд, динамит	Хүнд техник нь соёлын өвийн орчны хөрсийг дагтаршуулах, чичирхийлэл ба өрөмдлөг нь соёлын өвд таагүй нөлөө үзүүлэх, үүнтэй холбоотойгоор орон нутгийн иргэдтэй нийгмийн харилцааны зөрчил үүсэх
11	Орчны үзэгдэх байдал, байгалийн гоо үзэмж	Судалгааны суурин, хээрийн судалгааны шугамууд	Судалгааны суурин харагдах орчинтой зохицохгүй байх, хайгуулын шугамын дагуух ургамалын талхагдал нь газар орчны үзэгдэх байдалд нөлөөлөх нь
№	ХБО ба нийгмийн параметрууд	Нөлөөлөх эх үүсвэр	Таамагласан нөлөөлөл

12	Чимээ шуугиан ба чичиргээ вибраци	Вибросейс ба түүнтэй холбоотой төхөөрөмжүүд, хүнд машин техникүүд, динамит дагалдах бульдозер,	Хүн, мал амьтны амьдрах орчинд таагүй нөлөө үзүүлэх Судалгааны суурингийн ажилчид болон ойролцоох иргэдийн амьдрах орчинд таагүй нөлөө үзүүлэх
13	Хатуу ба шингэн хог хаягдал	Судалгааны суурин, талбай дээрх ажлын байр	Гадаргын хөрс, ус болон гүний усыг бохирдуулах, таагүй үнэр, эрүүл мэндийн эрсдэл
14	Нийгмийн хэв шинжүүд	Ажиллах хүчний урсгал, Сейсмийн хайгуулын шугамын дагуух үйл ажиллагаа	Орон нутгийн иргэд болон гаднаас ирсэн ажилчдын хооронд таагүй харилцаа үүсэх, Орон нутаг нийгэм соёлын онцлог шинж алдагдах
15	Эдийн засгийн хэв шинжүүд	Ажлын байр бий болох, тендер ба хангалт	Амьдралын чанар сайжирна, бизнесийн боломжууд гарч ирнэ, нийгмийн хөрөнгө оруулалт, бэлэн мөнгөний урсгал, ажил эрхлэлтийн хэлбэрт өөрчлөлт гарах, Уламжлалт амьдралын хэв маяг өөрчлөгдөх
16	Ажилтай холбоотой эрүүл мэнд аюулгүйн асуудал	Судалгааны суурин ба ажлын талбайн орчин	Ажиллагсдын гэмтэл, галын аюул, Тоосжилт, чимээ шуугиан хорт бодисын ялгарлаас эрүүл мэнд муудах, эрүүл мэндтэй холбоотой бусад эрсдэл
17	Харуул хамгаалалт ба олон нийтийн аюулгүй байдал	Ажиллах хүчний харуул хамгаалалт	Төслийн үйл ажиллагаатай холбоотой харуул хамгаалалт сайжрах, харуул хамгаалалттай холбоотой нутгийн иргэдийн үзэл бодол ил болох

Дээр өгүүлсэн болзошгүй нөлөөллийн судалгааны дүнгээс үзэхэд “Гурвантэс-XXXV” талбайд нүүрсний давхаргын метан хийн хайгуулын ажил гүйцэтгэх төслийн үед байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг агаар, хөрс, ургамал, газрын доорх ус зэрэгт нөлөөлөх сөрөг нөлөөг бууруулахад чиглэсэн, хөрсийг бохирдол, элэгдлээс хамгаалах, агаарын бохирдлын нөлөөллийг бууруулах, хамгаалах зэрэг арга хэмжээнүүдийг байгаль орчинд ээлтэй байдлаар хэрэгжүүлэн үйл ажиллагаа явуулах юм.

## **ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ**

### **4.1 Байгаль орчныг хамгаалах зорилго, зорилт:**

“Гурвантэс XXXV” талбайд нүүрсний давхаргын метан хийн хайгуулын ажил гүйцэтгэх төслийн 2023 оны Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа “Эх Монголын Байгаль” ХХК-ийн 2022 боловсруулж батлуулсан “Гурвантэс XXXV” талбайд нүүрсний давхаргын метан хийн хайгуулын ажил




гүйцэтгэх төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангаар тодорхойлогдсон төсөл хэрэгжүүлэгчийн хүлээх үүрэг амлалтаас гадна Монгол Улсын Байгаль орчны багц хууль, холбогдох дүрэм журам, стандартуудын шаардлагыг мөрдлөг болгон боловсруулсан бөгөөд энэ төлөвлөгөөнд тусгагдсан үүрэг даалгавруудыг биелүүлэхийг гол зорилго болгон биелэлтийг хангаж ажилласан.

## **4.2 Хамрах хүрээ**

“Гурвантэс ХХХV” талбайд 2023 онд хайгуулын 8 цооногт өрөмдлөг хийхээр төлөвлөсөн боловч хайгуулын цооног өрөмдөх ажил маань тодорхойгүй хугацаагаар хойшилсон, туршилт олборлолтын 3 цооног өрөмдөх ажил амжилттай болсон. Мөн төслийн кемпийн бүтээн байгуулалтын ажил хийгдсэн. Ажилчдын ХАБ,ЭА болон амьдрах орчны халдвар хамгаалал ая тухтай байдлыг харгалзан Кемпийн менежмент, катерингийн үйлчилгээ үзүүлдэг мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулж хамтран ажилласан.

### **4.2.1 Кемп төлөвлөлт**

Төслийн кемп нь Оффис, Ажилчдын амрах гэр, Гал тогоо, Угаалгын газар, боловсон нойл, Үндсэн лаборатори, харуул хамгаалалт шалган нэвтрүүлэх байр, дээж хадгалах талбай, каротажийн станц тусгаарлалтын хашаа, тээврийн хэрэгсэлийн паркийн талбай, цуглах цэг, засварын төв, шингэн хог хаягдал болон хуурай хог хаягдал цуглуулах цэг гэсэн байгууламжуудтай байхаар төлөвлөсөн. Кемпийн барилгын ажлыг энэ чиглэлээр мэргэшсэн олон жилийн ажлын туршлагатай компанитай хамтран үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөсөн боловч төлөвлөгөөт 2023 ондоо капитал барилгын ажил хойшлогдож 2024 онд хийхээр болоод байна.



Зураг 18. Кемпийн ерөнхий төлөвлөгөө



**Зураг 19. Кемпийн харагдах байдал**

## **ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

### **5.1 АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХАД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ**

#### 5.1.1 Замын тэмдэг тэмдэглэгээ

Төслийн үйл ажиллагааны нөлөөгөөр үүсэх тоос шороо болон хорт хий, үнэр агаар орчныг бохирдуулах сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор тээврийн хэрэгслийн хурдны хязгаарыг тогтоох 10, 20, парк, гол зам, туслах зам гэх мэт тэмдэг тэмдэглэгээг Туршилт олборлолтын талбайн орчинд байрлуулан агаар орчинд тоосжилт үүсгэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.



**Зураг 20. Замын тэмдэг байршуулсан байдал**



5.1.2 Хог хаягдал түр хадгалах сав, ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулан хамтран ажиллах.

Ажилчдын унд, ахуйн хэрэглээнээс гарсан хатуу хог хаягдлыг зориулалтын түр цэгт хадгалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ Хог хаягдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн тавигдах шаардлагыг хангасан зориулалтын савыг кемпд байрлуулан ашиглаж байна.

#### **Хог хаягдлын тухай хууль**

#### **15 дугаар зүйл. Хогийн саванд тавигдах шаардлага**

15.1.Нийтийн эдэлбэр газар байршуулах хогийн сав дараахь шаардлагыг хангасан байна:

15.1.1.хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн;

15.1.2 Галт тэсвэртэй материалаар хийгдсэн;


15.1.3.хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн.



**Зураг 21. Кемпийн хог хаягдлын түр ангилан ялгах хог хаягдлын сав**

Мөн хог хаягдлын тухай хуулийн 4.1.23."хог хаягдлын төвлөрсөн цэг" гэж хог хаягдал төвлөрүүлж, булшлах зөвшөөрөгдсөн газрыг заалтын дагуу Өмнөговь аймгийн Гурвантэс сумын “Шугшаа Уул” ОНӨААТҮГ-тай ХОГ ХАЯГДАЛ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ байгуулж хамтран ажиллаж, хог хаягдлыг зөвшөөрөгдсөн цэгт тээвэрлүүлэн ажилласан. /Хавсралт 5/





**Зураг 22. “Шугшаа уул” ОНӨААТҮГ газартай байгуулсан хог хаягдлын тээвэрлэх гэрээ**

5.1.3 Салхи ихтэй болон автомашины хөдөлгөөн ихтэй үед тоосжилт дарах усалгаа хийсэн. Салхины хур ихтэй үед Туршилт олборлолтын цооног орчимд нүүрс тээврийн зам болон орон нутгийн замаар зорчиж байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс маш их тоосжилт үүсдэг тул тоос дарах усалгааг хийж гүйцэтгэсэн.





**Зураг 23. Зам талбайн тоос дарах усалгаа хийж буй байдал**

5.1.4 Өрөмдлөгийн машинаас дуу чимээ, доргио чичиргээ агаар орчинд үүсэж хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх дараах арга хэмжээг авсан.

Туршилт олборлолтын цооног өрөмдөх ажил, туршилт олборлолтын үйл ажиллагааны явцад үүсэх дуу чимээнээс сонсох эрхтэнг хамгаалахын тулд ажилтнуудад чихний бөглөө, чихэвч зэргийг олгож, сонсгол хамгаалах хэрэгсэлийг хэрэглэж байгаад хяналт тавьж ажилласан.



**Зураг 24. Өрөмдлөгийн ажилтнуудад тарааж өгсөн чихний бөглөө, чихэвч**



### АЖИЛТАНД ЧИХНИЙ БӨГЛӨӨ, ЧИХЭВЧ ОЛГОСОН БҮРТГЭЛ

Зорилго: Төслийн үйл ажиллагааны явцад өрөмдлөгийн машинаас гарах дуу чимээний бохирдлоос хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж сонсох эрхтний өвчлөл үүсгэхээс урьдчилан сэргийлж чихний бөглөө, чихэвчийг өрөмдлөгийн талбай, туршилт олборлолтын цооног орчим ажилладаг ажилтнуудад олгож хамгаалах юм.

№	Овог нэр	Албан тушаал	Хүлээлгэн өгсөн тоо хэмжээ	Олгосон огноо	Гарын үсэг
1	П. Сэлэнгэ	ХАВЧИЛ	2	2025-08-18	Сэлэнгэ
